



ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГТГЭЛИЙН  
ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИЙН ПАРКУУДЫН  
ХӨГЖЛИЙН  
**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ – 1448**

УЛААНБААТАР ХОТ  
2024

|                                         |                                                                                                                                                                               |
|-----------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Менежментийн өндөр бүтээмжтэй тогтолцоо | ✓ УТП-ийн үйлдвэрүүдэд бүтээмжийн удирдлага хэрэгжүүлнэ.                                                                                                                      |
|                                         | ✓ УТП-уудын нэгжүүдийн түүхий эдийн тогтвортой ханган нийлүүлэлтийн удирдлага хэрэгжүүлнэ                                                                                     |
| Хөрөнгө оруулалт, санхүүгийн систем     | ✓ Төр хувийн хэвшлийн түншлэлийн олон төрөлт санхүүжилт, хамтын ажиллагааны загваруудыг (PPP, BOT, PFI, TOT, BOST, ABS гэх мэт) УТП-ийн төслүүдэд зориулж, загварчлал бэлтгэх |
|                                         | ✓ УТП-ийн төслийн хөрөнгө оруулалтын сан байгуулах санал, судалгаа боловсруулах                                                                                               |
|                                         | ✓ Төслүүдийн хөрөнгө оруулалтын эрсдэлийн үнэлгээ, санхүүгийн зуучлал, даатгалын зуучлалыг хэрэгжүүлэх                                                                        |
|                                         | ✓ УТП-ийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах журам боловсруулж, хуульд нийцүүлэх                                                                                          |
|                                         | ✓ Дэвшилтэт технологи бүхий санхүү, төлөвлөлт, хяналт, удирдлагын нэгдсэн системийг бүх УТП-ийн хэмжээнд нэвтрүүлнэ.                                                          |
|                                         | ✓ Хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн гүйцэтгэлд хяналт тавьж, өгөөж хүртэн дараа дараагийн төсөл хөтөлбөр санхүүжүүлэх эх үүсвэрийн өсөлтийг хангаж ажиллана.                 |
| Төслийн үнэлгээ, хяналтын цогц механизм | ✓ УТП-уудын Нэгдлийн төслүүдэд хөрөнгө оруулалтын удирдлага хэрэгжүүлнэ                                                                                                       |
|                                         | ✓ Нэгдлийн төслийн үнэлгээ, хяналтын стратегийн дагуу УТП-ийн төслүүдийг нэгдсэн журмын дагуу үнэлж, хянах тогтолцоог бий болгоно                                             |
|                                         | ✓ УТП-уудын төслийн эрсдэлийн менежментийг нэвтрүүлнэ                                                                                                                         |
|                                         | ✓ Төслийн хяналт, удирдлагын цахим системтэй болно                                                                                                                            |
|                                         | ✓ Удирдлагын компанийг төслийн техникийн болон санхүүгийн хяналтыг өндөр түвшинд хийх чадамжтай болгоно                                                                       |
|                                         | ✓ УТП-ийн Нэгдлийн төслүүдэд өртөг зардлын удирдлага хэрэгжүүлэх                                                                                                              |
| Төсөл сонгон шалгаруулах механизм       | ✓ УТП-уудын ерөнхий төлөвлөлтийн дагуу олон улсад төсөл танилцуулах, сурталчлах хөтөлбөртэй болно.                                                                            |
|                                         | ✓ Гадаад улсад төсөл судлах, аж ахуйн нэгжүүдтэй холбоо тогтоох, хөрөнгө оруулагч нартай хамтын ажиллагаа өрнүүлэх нэгжтэй болох                                              |
|                                         | ✓ УТП-уудын төсөл сонгон шалгаруулах, гүйцэтгэгч сонгон шалгаруулах журамтай болно                                                                                            |

## ■ ЗӨВ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Үйлдвэрлэл технологийн паркуудад төлөвлөж буй хими-металлургийн хүнд үйлдвэрийн төслүүд нь Монгол улсын хувьд урьд өмнө хэрэгжиж байгаагүй, технологи, мэргэжлийн практик туршлага шаардсан байдал нь хүний нөөцийг урьдчилан бэлтгэх, өндөр түвшний мэргэжилтэй ажилчдыг татан ажиллуулах онцгой шаардлага тулгарч байна. Нэгдлийн 6 байршил дахь УТП-уудад төлөвлөж буй 2035 он гэхэд нийт 9933 ажлын байр шинээр бий болно гэж хөгжлийн төлөвлөгөөнд тооцсон бөгөөд эдгээр ажилчдын 15% нь өндөр түвшний мэргэжлийн ажилчид, 23% нь инженер техникийн ажилчид, 42% нь оператор, техникийн ажилчид, 20% нь захиргаа удирдлага, хөдөлмөр хамгаалал болон бусад түвшний ажилчид эзлэх юм. Үүнд: Химийн инженер, хими технологич, металлургич, металлын технологич, цахилгаан системийн автоматжуулалтын инженер, баяжуулалтын технологич, машин

тоног төхөөрөмжийн инженер, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын инженер, мэдээллийн технологич, авто инженер, цахилгааны инженер, материалын технологич, ус хангамж, ариутгал татуургын инженер, үйлдвэрийн дизайнер гэх мэт нарийн мэргэжлийн боловсон хүчин ихээр шаардлагатай. Мөн үйлдвэрлэлийн менежмент, инженер-эдийн засагч, төлөвлөлтийн чиглэлийн өндөр түвшний туршлагатай хүний нөөц манай улсад хомс байгаа нь эдгээр боловсон хүчнийг нэгдсэн бодлоготойгоор улсын хэмжээнд төлөвлөн бэлтгэх асуудал паркийн хөгжлийн тулгамдсан сорилт болоод байна. Монгол улсад хүнд үйлдвэрлэл, тэр дундаа хими металлургийн салбар сул хөгжсөнтэй холбоотой их дээд сургуулиудын мэргэжилтэн бэлтгэх нэр төрөл, чиглэл нарийвчилсан бус, хэт ерөнхий байгаа бөгөөд сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийх шаардлагатай байна. Мөн дэд бүтэц, үйлдвэрийн

бүтээн байгуулалтад давхардсан тоогоор 4500 орчим ажлын байр шаардлагатай.

6-н байршил дахь үйлдвэрлэл технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан 32 үйлдвэрийн өндөр түвшний мэргэжлийн ажилчдын ажлын байр, мэргэжлийн урьдчилсан тооцоолол нь дараах байдалтай байна.

График 2.1. УТП-уудын ажил мэргэжлийн бүтэц



Хүснэгт 21. УТП-ийн шаардлагатай мэргэжлийн ажилчдын ажлын байрны тооцоолол

|    | Мэргэжил                                   | Ажлын байрны тоо | Эзлэх хувь % |
|----|--------------------------------------------|------------------|--------------|
| 1  | Химийн инженер                             | 85               | 0.85         |
| 2  | Металлургич, металлын технологич           | 45               | 0.45         |
| 3  | Инженер-эдийн засагч                       | 32               | 0.32         |
| 4  | Үйлдвэрлэлийн инженер                      | 38               | 0.38         |
| 5  | Баяжуулалтын технологич                    | 62               | 0.62         |
| 6  | Автоматжуулалтын инженер                   | 45               | 0.45         |
| 7  | Цахилгааны инженер                         | 64               | 0.64         |
| 8  | Тоног төхөөрөмжийн инженер                 | 120              | 1.20         |
| 9  | Эрчим хүч, цахилгаан хангамжийн инженер    | 75               | 0.75         |
| 10 | Халаалт, агаар сэлгэлт, кондиционер        | 35               | 0.35         |
| 11 | Усан хангамж, ариутгах татуургын инженер   | 42               | 0.42         |
| 12 | Цахилгаан, электроник                      | 74               | 0.74         |
| 13 | Авто инженер                               | 50               | 0.50         |
| 14 | Механик инженер                            | 110              | 1.10         |
| 15 | Үйлдвэрийн автоматжуулалт                  | 64               | 0.64         |
| 16 | Нийлүүлэлтийн сүлжээ, логистик             | 20               | 0.20         |
| 17 | Усны барилга байгууламжийн инженер         | 55               | 0.55         |
| 18 | Сантехникийн инженер                       | 96               | 0.96         |
| 19 | Барилгын инженер                           | 32               | 0.32         |
| 20 | Барилгын материал үйлдвэрлэлийн технологич | 5                | 0.05         |

|    |                                                  |      |       |
|----|--------------------------------------------------|------|-------|
| 21 | Хаягдал боловсруулах технологич                  | 36   | 0.36  |
| 22 | Хот ба бүс нутгийн төлөвлөлтийн инженер          | 10   | 0.10  |
| 23 | Үйлдвэрлэлийн менежмент                          | 30   | 0.30  |
| 24 | Программ хангамж, мэдээллийн технологийн инженер | 90   | 0.90  |
| 25 | Робот ба хиймэл оюун ухааны инженер              | 32   | 0.32  |
| 26 | Хүрээлэн буй орчны инженер                       | 40   | 0.40  |
| 27 | Материал судлалын инженер                        | 45   | 0.45  |
| 28 | Үйлдвэрлэл, технологийн симуляцын инженер        | 20   | 0.20  |
| 29 | Эргономик, үйлдвэрийн дизайнер                   | 30   | 0.30  |
| 30 | Цахилгааны хөдөлгүүрийн инженер                  | 64   | 0.64  |
|    |                                                  | 1546 | 15.47 |

Монгол улсын хэмжээнд дээд боловсролын удирдлага, мэдээллийн цахим системд бүртгэлтэй зарим шаардлагатай мэргэжлээр төгсөгчдийн тоо дараах байдалтай байна.

**Хүснэгт 22. Шаардлагатай инженер мэргэжлээр төгсөгчдийн тоо**

| Мэргэжлийн индекс | Мэргэжлийн нэр                         | Төгсөгчдийн тоо |
|-------------------|----------------------------------------|-----------------|
| 073202            | Барилгын инженер                       | 5965            |
| 071304            | Цахилгааны инженер                     | 2560            |
| 072401            | Уул уурхайн ашиглалтын инженер         | 2029            |
| 071302            | Дулааны инженер                        | 1602            |
| 071501            | Механик инженер                        | 1567            |
| 071402            | Үйлдвэрлэлийн автоматжуулалт           | 809             |
| 072402            | Ашигт малтмал баяжуулалтын технологи   | 768             |
| 071201            | Байгаль орчныг хамгаалах технологи     | 556             |
| 053101            | Хими                                   | 474             |
| 071101            | Химийн инженерчлэл                     | 229             |
| 053301            | Физик                                  | 226             |
| 102201            | Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал | 201             |
| 071503            | Металлурги, металлын технологи         | 201             |
| 041305            | Логистик менежмент                     | 181             |
|                   |                                        | 17368           |

Дээрх 17 мянган төгсөгчдийн 27 хувь буюу 4700 гаруй нь уул уурхайн салбарт ажиллаж байгаа бөгөөд мэргэжлээрээ ажиллаагүй, бусад салбарт ажиллаж байгаа төгсөгчдийн бүртгэл, судалгааг нарийвчлан хийж, УТП-уудад ажиллах боломжийн талаар хувь хүмүүст мэдээлэл хүргэж, хүний нөөцийн нийлүүлэлтийг хангах талаар арга хэмжээ авна.

## 1. ӨНДӨР МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧИН ТАТАХ БОДЛОГО

Нэгдлийн 6 байршил дахь УТП-ийн төслүүдэд шаардлагатай өндөр түвшний мэргэжлийн боловсон хүчний тоо 1500 гаруй байгаа нь өнөөгийн Монгол улсын хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлттэй харьцуулахад томоохон сорилт, хүндрэл тулгарахаар харагдаж байна. Иймд дээрх ажиллах хүчнийг паркийн төслүүдэд ирж ажиллах дэмжлэг бүхий бодлого шаардлагатай. Түүнчлэн, төсөл хэрэгжих 6

байршил нь орон нутагт хэрэгжих тул тухайн газар шилжин суурьших, ажиллахад давуу тал бүхий таатай эрх зүйн орчныг бий болгох нь чухал байна. Тухайлбал, орон сууцавах, түрээслэхэд урт хугацааны нэн хөнгөлөлт бүхий зээл, буцалтгүй тусламж олгохоос гадна, тэдний үр хүүхдүүдийн суралцах, хөгжих боломжоор хангасан сайн чанартай сургууль, цэцэрлэг барьж байгуулах зэрэг өргөн хүрээний татах бодлого баримтална. Мөн гадаадын өндөр мэргэжлийн хүний нөөцийг урьж, сонгон шалгаруулж ажиллуулан, дотоодын хүний нөөцөө сургах чиглэлээр хөтөлбөр боловсруулна.

## 2. ИНЖЕНЕР БЭЛТГЭХ, ДАДЛАГАЖУУЛАХ БОДЛОГО

Инженер, мэргэжилтэн бэлтгэх бодлогыг 10 жилээр төлөвлөж, ирээдүйд УТП-д баригдах үйлдвэрүүдийн төлөвлөлттэй уялдуулан Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчид, оюутан,

мэргэжилтэй ажилчид зэрэг олон түвшинд хүний нөөцийн хөтөлбөрийг боловсруулах нь зүйтэй. Аливаа улс орон аж үйлдвэржилтийн бодлогоо урт хугацаанд үе шаттайгаар төлөвлөхдөө эн тэргүүнд ажиллах хүчний олон жилийн нөөцийг нэгдсэн бодлоготойгоор бэлтгэдэг. Монгол улсын хувьд нийт 770 мянган бүртгэлтэй ажилтан байгаагийн 8 хувь буюу 61 мянган ажилтан уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа бөгөөд үүний 4700 нь дээд боловсролтой инженерүүд байна. Дээрх инженерүүдийн 65 хувь нь геологи, хайгуул, уул уурхайн ашиглалт, олборлолтын чиглэлээр мэргэшсэн бол 27 хувь нь мэдээллийн технологи, тоног төхөөрөмж, механик, цахилгаан, ус дулааны чиглэлийн инженерүүд байна. Харин үлдсэн 8% буюу 376 хими технологи, металлурги, металлын технологи, ашигт малтмал баяжуулалтын инженер байгаа нь 6 байршил дахь УТП-д шинээр инженер, техникийн ажилчдыг олноор бэлтгэх шаардлага байгааг харуулж байна. Уг стратегийн чиглэлийн хүрээнд гадаад дотоодын их дээд сургууль, МСҮТ-тэй хамтран ажиллах, Монгол улсын инженерийн боловсон хүчний нэгдсэн бүртгэл үүсгэж, Нэгдлийн хүрээнд хүний нөөцийн нэгдсэн бодлого явуулах зэрэг олон шатны арга хэмжээ авна.

### **3. ДУНД ТҮВШНИЙ МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛЧИД БЭЛТГЭХ БОДЛОГО**

Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй МСҮТ-үүдтэй хамтран ажиллаж гагнуурчин, цахилгаанчин, засварчин, тоног төхөөрөмжийн оператор, аюулгүй ажиллагааны техникч зэрэг УТП-уудад хэрэгцээтэй боловсон хүчнийг төлөвлөж, бэлтгэнэ. Ингэхдээ 2025–2026 онд 1000 мэргэжилтэн, 2027–2028 онд 1000 мэргэжилтэн бэлтгэж ажлын байраар хангана. 6 байршил дахь орон нутаг дахь МСҮТ-үүдэд сургалтын хөтөлбөр, орчныг сайжруулах, материаллаг баазад хөрөнгө оруулах чиглэлээр хөтөлбөр боловсруулж ажиллана. Мөн Нэгдлийн нийт хүний нөөцийн нэгдсэн платформуур дамжуулан УТП-уудын бүтээн байгуулалтад мэргэшсэн ажилтнуудыг ажиллуулах, үйлдвэрийн төслүүдэд богино болон урт хугацааны гэрээгээр ажиллуулах зэрэг Нэгдлийн дотоод нөөцийн менежмент хийнэ.

### **4. ПАРКУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН НЭГДСЭН БОДЛОГО**

Нэгдлийн 6 байршил дахь үйлдвэрлэл, технологийн паркуудын хүний нөөцийг паркийн удирдлагын компанийн зүгээс нэгдсэн бодлого баримтлах бөгөөд энэ нь нэгжүүдийн ажлын байр, албан тушаалд ажилтнуудыг сонгон шалгаруулах,

тохирсон ажлын байранд ажиллуулах, хөдөлмөрлөх таатай нөхцөлөөр хангах, ажилтны хөдөлмөрийг зөв хуваарилан ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, түүнд тохирсон ажлын хөлс, шагнал урамшуулал олгох, хариуцлага тооцох, сургаж хөгжүүлэх, нийгмийн асуудлыг хэсэгчлэн болон бүрэн хөнгөлөлттэй байдлаар шийдвэрлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, цаашид паркийн хүний нөөцийн үйл ажиллагаанд баримтлан ажиллах чиглэлийг тогтоох явдал юм. УТП-уудын төслүүдэд ажиллах нийт ажлын байрыг хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөх бөгөөд, УТП-уудын нийт хэмжээнд хүний нөөцийн биг дата үүсгэж, нэгжүүдийн ажлын байрны нөөцийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ. Хүний нөөцийг сургах, дадлагажуулах, ажлын байр зарлах, сурталчлах, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах журам боловсруулж, ажлын байрны нэг цонхны үйлчилгээг иргэн болон нэгжүүдэд зориулж гүүр болж ажиллана. Түүнчлэн хамгийн үр дүнтэй хөрөнгө оруулалтыг ажилтнуудыг байнгын сургалтад хамруулж, хөгжүүлэх хөтөлбөр гэж тодорхойллоо.

### **5. ЭРДЭМТЭД, СУДЛААЧДЫГ ДЭМЖИХ, ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО**

Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанд судалгаа хөгжүүлэлт, технологи, инновацын чиглэлээр дотоодын болон гадаадын эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллаж, тэдний судалгаа, бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, саналыг тусгах, дэмжих чиглэлээр анхаарч ажиллана. Энэ чиглэлээр жил бүр УТП-ийн төслүүдийн талаарх хэлэлцүүлэг зохион байгуулж, шинэ бүтээл, инновацын уралдааныг зарлан, тэдний санал, мэдээллийг харилцан солилцох, хөрөнгө оруулагч нартай холбох, паркийн төслүүдэд хамтран ажиллах боломжийг олгоно. Эрдэмтэн судлаачдын багийн санаачилсан шинэ төсөл, санаачилгыг урамшуулах, дэмжих журам гаргаж, тэдний бүтээлийг УТП-ийн хүрээнд эдийн засгийн эргэлтэд оруулна. Мөн тэднийг УТП-уудад судалгаа, шинжилгээ, туршилт хийх орчин нөхцөлөөр хангаж, гадаад улсад туршлага судлах, судалгаа хийх боломжийг бүрдүүлнэ.

### **6. ПАРКУУДАД АЖИЛЛАЖ, АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИН**

6 байршил дахь УТП-уудад ажилчдын амьдрах, ажиллах таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлээр орон сууц, худалдаа үйлчилгээний хотхонуудыг барьж байгуулах бөгөөд, тэдэнд зориулсан нийгмийн дэд бүтцүүдийг шийдвэрлэнэ. Үүнд, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сувилал, онцгой байдал, цагдаа зэрэг нийгэм, эрүүл мэнд, аюулгүй

байдлын бүрэн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. 2035 он гэхэд Монгол улсын жишиг, ажиллаж амьдрах хамгийн таатай орчин нөхцөл бүрдүүлсэн байх зорилт тавьж байна.

## 7. ӨНДӨР ТҮВШНИЙ УДИРДЛАГЫН БАГ

Үйлдвэрлэл, технологийн паркуудын санхүү, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, технологи хөгжүүлэлт, нэгжүүдтэй гэрээ байгуулах, олон талт хамтын ажиллагаа өрнүүлэх зэрэг бүхий л түвшний удирдлагыг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлнэ. Ингэхдээ төслийн менежментийн ISO 21500 стандартыг нэвтрүүлж, олон улсын паркийн удирдлагын жишигт нийцсэн удирдлагын тогтолцоог бий болгоно.

## 8. УДИРДЛАГЫН КОМПАНИЙН ОНОВЧТОЙ БҮТЭЦ

Эрдэнэс УТП ХХК-ийн бүтэц орон тоог хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулж, тухайн цаг нөхцөлийн бодит хэрэгцээ шаардлагад үндэслэж шинэчлэн зохион байгуулах төлөвлөгөө гаргана. Паркийн удирдлага, хүний нөөцийг ашиг сонирхлоос ангид, мэргэжлийн байх үндсэн шаардлагад тулгуурлаж, сонгон шалгаруулалт, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг олон улсын жишигт нийцсэн байдлаар оновчилно.

Паркийн хөгжлийн **зөв хүний нөөцийн бодлого** баримтлах стратегийн хэрэгжүүлэх хөтөлбөр

| ЗОРИЛТ                                        | ХӨТӨЛБӨР                                                                                                                                                      |
|-----------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Өндөр мэргэжлийн боловсон хүчин татах бодлого | ✓ Монгол улсын хэмжээнд УТП-ийн төслүүдэд шаардлагатай боловсон хүчний нарийвчилсан судалгаа гаргана                                                          |
|                                               | ✓ Өндөр мэргэжилтэй боловсон хүчнийг орон нутагт ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр цогц хөтөлбөр гаргах                                    |
|                                               | ✓ Өндөр мэргэжлийн боловсон хүчнийг мэргэжил, туршлагыг үндэслэж А, В, С, D, E түвшинд ангилж цалин урамшуулал, нийгмийн хангамжийн чиглэсэн бодлоготой болох |
|                                               | ✓ Өндөр мэргэжлийн боловсон хүчин тухайн орон нутагт орон сууц авах, түрээслэхэд татаас, дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх                            |
|                                               | ✓ Өндөр мэргэжилтэй боловсон хүчний хүүхдийн боловсролд дэмжлэг үзүүлэх журамтай болох                                                                        |
|                                               | ✓ Өндөр мэргэжилтэй боловсон хүчний нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ, даатгалын үйлчилгээний дэмжлэг бүхий тогтолцоог бүрдүүлэх                       |
|                                               | ✓ УТП-д хэрэгжүүлэх старт-ап бизнесийг дэмжих хөтөлбөртэй болох                                                                                               |
|                                               | ✓ Судалгаа хөгжүүлэлтийн чиглэлээр амжилт гаргасан, патент эзэмшсэн боловсон хүчнийг дэмжих бодлоготой болох                                                  |
|                                               | ✓ Боловсролын зэрэгт хамааруулж нэмэлт цалин урамшуулал олгох журамтай болох                                                                                  |
|                                               | ✓ KPI үнэлгээнд суурилсан цалин хөлсний системтэй болох                                                                                                       |
|                                               | ✓ Гадаад улсад сурч буй, төгссөн, ажиллаж буй өндөр түвшний мэргэжилтний судалгааг гаргаж, холбоо байгуулах                                                   |
| Инженер бэлтгэх, дадлагажуулах бодлого        | ✓ Өндөр мэргэжлийн боловсон хүчин тухайн орон нутагт орон сууц авах, түрээслэхэд татаас, дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх                            |
|                                               | ✓ Өндөр мэргэжилтэй боловсон хүчний нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ, даатгалын үйлчилгээний дэмжлэг бүхий тогтолцоог бүрдүүлэх                       |
|                                               | ✓ УТП-д хэрэгжүүлэх старт-ап бизнесийг дэмжих хөтөлбөртэй болох                                                                                               |
|                                               | ✓ Судалгаа хөгжүүлэлтийн чиглэлээр амжилт гаргасан, патент эзэмшсэн боловсон хүчнийг дэмжих бодлоготой болох                                                  |
|                                               | ✓ Боловсролын зэрэгт хамааруулж нэмэлт цалин урамшуулал олгох журамтай болох                                                                                  |
|                                               | ✓ KPI үнэлгээнд суурилсан цалин хөлсний системтэй болох                                                                                                       |
|                                               | ✓ Гадаад улсад сурч буй, төгссөн, ажиллаж буй өндөр түвшний мэргэжилтний судалгааг гаргаж, холбоо байгуулах                                                   |
| Инженер бэлтгэх, дадлагажуулах бодлого        | ✓ Гадаадын өндөр түвшний мэргэжилтэн ажиллуулах, түүнд дотоодын мэргэжилтнүүдийг дагалдуулах, сургах бодлоготой болох                                         |
|                                               | ✓ УТП-ийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан үйлдвэрүүдийн ижил төстэй гадаадын үйлдвэрт дадлагажих, 6-12 сараар ажиллах боломжийг бүрдүүлэх                      |
|                                               | ✓ УТП-ийн төслүүдэд бэлтгэж буй боловсон хүчнийг Нэгдлийн үйлдвэрүүдэд ажиллуулах, дадлагажуулах нэгдсэн хөтөлбөр боловсруулах                                |
|                                               | ✓ Шаардлагатай хүний нөөцийг сургах, бэлтгэх чиглэлээр их дээд сургуулиудад тусгай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, тэтгэлэг олгох                             |
|                                               | ✓ Шаардлагатай мэргэжлийн дагуу гадаадын тухайн мэргэжлээр өндөр түвшний сургалттай их дээд сургуульд сургах, тэтгэлэг олгох                                  |
|                                               | ✓ Дотоодын их дээд сургуулиудтай хамтран гадаадын их дээд сургуультай гурвалсан гэрээ байгуулж, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх                                |
|                                               | ✓ Их дээд сургууль, МСҮТ-үүдэд сургалт, судалгааны материаллаг баазыг бүрдүүлэх                                                                               |
| Инженер бэлтгэх, дадлагажуулах бодлого        | ✓ Нэгдлийн хүний нөөцийн нэгдсэн бодлого боловсруулж, шаардлагатай инженер техникийн ажилчдыг УТП-ийн бүтээн байгуулалт, төслүүдэд ажиллах журам боловсруулах |

|                                                  |                                                                                                                                                                                                                                                           |
|--------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Инженер бэлтгэх, дадлагажуулах бодлого           | ✓ Боловсролын яамтай хамтран оюутан элсүүлэх, мэргэжил сонголтын хөтөлбөр хэрэгжүүлэх                                                                                                                                                                     |
|                                                  | ✓ Мэргэжлийн холбоодуудтай хүний нөөц бэлтгэх, нийлүүлэх хамтын ажиллагаатай болох                                                                                                                                                                        |
|                                                  | ✓ УТП-ийн гадаадын стратегийн түншлэгчтэй хамтран хүний нөөц бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх                                                                                                                                                                 |
| Дунд түвшний мэргэжилтэй ажилчид бэлтгэх бодлого | ✓ Монгол улсын хэмжээнд нийт үйл ажиллагаа явуулж буй МСҮТ-үүдтэй хамтарч, УТП-д шаардлагатай дунд түвшний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр боловсруулах                                                                                              |
|                                                  | ✓ 6 байршил дахь МСҮТ-ийн сургалтын чанар, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх                                                                                                                                                                                      |
|                                                  | ✓ УТП-уудын нэгжүүдийн хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн нэгдсэн платформтой болж, захиалга авах, нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх                                                                                                                            |
|                                                  | ✓ Гадаадын мэргэжилтэй ажилтан бэлтгэх байгууллагуудтай хамтран ажиллах                                                                                                                                                                                   |
|                                                  | ✓ Дотоодын хүний нөөцийн зөвлөх үйлчилгээний байгууллагуудтай хамтран ажиллах                                                                                                                                                                             |
|                                                  | ✓ УТП-бүрд үйлдвэрлэлийн дадлага, сургалт явуулах орчин, нөхцөл бүрдүүлэх                                                                                                                                                                                 |
| Паркуудын хүний нөөцийн нэгдсэн бодлого          | ✓ 6 байршил дахь УТП-д шаардлагатай хүний нөөцийн нарийвчилсан судалгаа гаргаж, ажлын байранд тавигдах шаардлага, ажлын байрны тодорхойлолтуудыг нэг бүрчлэн гаргах                                                                                       |
|                                                  | ✓ Паркийн хүний нөөцийн нэгдсэн цахим программтай болох                                                                                                                                                                                                   |
|                                                  | ✓ Нэгжүүдийн хүний нөөцийн захиалга өгөх, бүртгэх, нийлүүлэх үйлчилгээний системтэй болох                                                                                                                                                                 |
|                                                  | ✓ Нэгдлийн хэмжээнд нийт хүний нөөцийн мэдээллийн сан бүрдүүлж, УТП-ийн төслүүдэд хамтран ажиллах механизмтай болох                                                                                                                                       |
|                                                  | ✓ Паркийн удирдлагын компанид Паркийн хүний нөөцийн хэлтэстэй болох                                                                                                                                                                                       |
|                                                  | ✓ Орон нутгуудтай тухайн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах хамтын ажиллагаа, хөтөлбөртэй болох                                                                                                                                                   |
|                                                  | ✓ Ажилчдын тогтвортой урт хугацаанд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх дэмжих хөтөлбөртэй болох                                                                                                                                                                  |
| Эрдэмтэд, судлаачдыг дэмжих, хөгжүүлэх бодлого   | ✓ УТП-уудын төслүүдэд технологи, инновац нэвтрүүлэх, судалгаа хийх чиглэлээр эрдэмтэн судлаач нартай хамтран ажиллах                                                                                                                                      |
|                                                  | ✓ Эрдэмтэн судлаачдын технологийн амжилттай шийдэл, шинэ санаа, төсөл хөтөлбөрүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэхэд эдийн засгийн үр өгөөжийг үнэлж, хөрөнгө оруулалт хийх, хувьцаа эзэмшүүлэх, өндөр урамшуулал олгох бодлоготой болох |
|                                                  | ✓ УТП-уудад судалгаа хөгжлийн төв байгуулж, эрдэмтэн судлаач нарыг ажиллах амьдрах орчныг бүрдүүлэх                                                                                                                                                       |
|                                                  | ✓ Эрдэмтэн судлаач нарыг УТП-т туршилт судалгаа хийх, гадаадын оронд судалгаа хийх боломжоор хангах                                                                                                                                                       |
|                                                  | ✓ Их дээд сургууль, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн эрдэмтдийн багийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт зуучлах, үйлдвэрлэлд нэвтрэх боломжоор хангах                                                                                       |
|                                                  | ✓ УТП-уудад ажилчдын орон сууц, хотхоны төслийг орон нутгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулж хэрэгжүүлэх                                                                                                                                                   |
| Паркуудад ажиллаж, амьдрах таатай орчин          | ✓ УТП-уудын ажилчдын хүүхдүүдэд хангалттай хүрэлцэхүйц сургууль, цэцэрлэг төлөвлөж, барих                                                                                                                                                                 |
|                                                  | ✓ УТП бүрд анхан шатны тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн оношилгоо шинжилгээний төв байгуулах                                                                                                                                                              |
|                                                  | ✓ УТП-уудад амрах, чөлөөт цагаа өнгөрөөх ногоон байгууламж, соёл амралт, худалдаа үйлчилгээний цогцолборуудыг барьж байгуулах                                                                                                                             |
|                                                  | ✓ Паркийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулж бүтэц, орон тооны цаг хугацаатай уялдуулсан төлөвлөлт гаргах                                                                                                                                                    |
| Удирдлагын компанийн оновчтой бүтэц              | ✓ 6 байршил дахь УТП-ийн захиргаа удирдлагын бүтэц бий болгох                                                                                                                                                                                             |
|                                                  | ✓ УТП-ийн удирдлагын компанийн ажилтнуудын чадавхыг сайжруулах, гадаад дотоодод сургах хөтөлбөр хэрэгжүүлэх                                                                                                                                               |
| Өндөр түвшний удирдлагын баг                     | ✓ Нэгдлийн УТП-ийн төсөл бүр дээр удирдлагын мэргэжлийн баг бүрдүүлж, олон улсын төслийн удирдлагын стандарт хэрэгжүүлэх                                                                                                                                  |
|                                                  | ✓ УТП-ийн төслүүдэд гадаадын туршлага, чадавх бүхий мэргэжлийн баг, байгууллагатай хамтран удирдлага, хяналт хэрэгжүүлэх                                                                                                                                  |
|                                                  | ✓ Төслүүдийн удирдлагын багийг үр дүнтэй уялдуулж урамшуулах тогтолцоотой болох                                                                                                                                                                           |
|                                                  |                                                                                                                                                                                                                                                           |



**- СТРАТЕГИЙН ЗОРИЛТОД ХҮРЭХЭД ТУЛГАРАХ  
ГАДААД ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС**

|           | МАКРО ОРЧИН БУЮУ ГАДААД ХҮЧИН<br>ЗҮЙЛС                                                                                                                                                                                                           | МИКРО БУЮУ ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС                                                                                                                                                                                                                                               |
|-----------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| ДАВУУ ТАЛ | ✓ УТП-уудын 200 км-ын радиус доторх ашигт малтмалын нөөц баялаг                                                                                                                                                                                  | ✓ УТП-уудын байршил дахь нэгдлийн ашигт малтмалын нөөц тодорхой                                                                                                                                                                                                             |
|           | ✓ УТП-уудын 200 км-ын радиус доторх хувийн хэвслүүдийн шаардлагатай ашигт малтмалын батлагдсан нөөц нь үндсэн болон дагалдах үйлдвэрүүдийг хөгжихөд хангалттай хүрэлцэхүйц байна.                                                                | ✓ Нэгдлийн ашигт малтмалын нүүрс, зэс, төмрийн нөөц үндсэн үйлдвэр байгуулахад үйлдвэрлэлийн 50-с доошгүй жилийн нийлүүлэлт хийх боломжтой                                                                                                                                  |
|           | ✓ Нүүрс-хими, металлургийн технологи сайжирч, өртөг буурч байна                                                                                                                                                                                  | ✓ Нэгдлийн хувьд төрийн-нийтийн өмч болох ашигт малтмалын нөөцүүдийг эзэмших, ашиглах, менежмент хэрэгжүүлэх боломжтой                                                                                                                                                      |
|           | ✓ БНХАУ-д үйлдвэрийн технологи, инновац өндөр түвшинд хөгжиж байгаа нь ойроос тоног төхөөрөмж, технологи судлах, худалдан авах, дагалдах эд анги, сэлбэг хэрэгслийн нийлүүлэлтийн логистикийг бага өртгөөр шуурхай зохион байгуулах давуу талтай | ✓ Нэгдлийн хэмжээнд нэгдсэн стратегитай болсон, нэгдлийн зарчмаар хамтарсан нөөцийн удирдлага хэрэгжүүлэх боломжтой                                                                                                                                                         |
|           | ✓ УТП-уудын 200-ын радиус дотор 275ГВ-ийн салхины, 540ГВ-ийн нарны эрчим хүчний нөөцтэй буюу дунджаар салхи 6000 цаг/жил, нар 4000 цаг/жил эрчим хүч үйлдвэрлэх потенциалтай                                                                     | ✓ Төлөвлөж буй 6 байршил нь дэд бүтэц харьцангуй хөгсөн, хот сууринуудын дэргэд, сүүлийн 20–40 жил уул уурхай хүнд үйлдвэрлэл төвлөрч хөгжсөн нутгууд учир хүний нөөц арвинтай, орон нутгийн иргэдийн уул уурхай, аж үйлдвэрт хандах хандлага сайн, ойлголт өндөртэй байна. |
|           | ✓ Сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалт, цахилгаан үйлдвэрлэлийн өртөг буурч байна                                                                                                                                                            | ✓ Нэгдлийн харьяа компаниудын ажиллах хүчин нь уул уурхай, үйлдвэрийн салбарт олон жилийн туршлага хуримтлуулсан, мэргэшсэн байдал                                                                                                                                          |
|           | ✓ Хөрш зэргэлдээ ӨМӨЗО-нд 110 гаруй улсын зэрэглэлийн үйлдвэрлэл, технологийн парк үйл ажиллагаа явуулж байгаа нь паркийн хөгжлийн туршлага судлах боломжийг                                                                                     | ✓ Нэгдлийн үйлдвэрлэл технологийн паркийн стратеги чиглэл тодорхой                                                                                                                                                                                                          |
|           | ✓ Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого зэрэг хөгжлийн баримт бичгүүд                                                                                                                                                                        | ✓ Паркуудын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан                                                                                                                                                                                                                              |
|           | ✓ Баялагийн сангийн тухай хууль батлагдсанаар хөгжлийн төслүүдэд хөрөнгө оруулалт хий боломж бүрдсэн                                                                                                                                             | ✓ Зарим үйлдвэрүүдийн ТЭЗҮ, БОННУ, технологийн түвшний үнэлгээ хийгдсэн                                                                                                                                                                                                     |
|           | ✓ Ашигт малтмалыг боловсруулж, нэмүү өртөг шингээх чиглэлийг олон нийт, төр засаг бүх түвшинд дэмжих хандлагатай                                                                                                                                 | ✓ Нүүрс-дулааны цахилгаан станц байгуулах түүхий эдийн нөөц арвин                                                                                                                                                                                                           |
| СУЛ ТАЛ   | ✓ УТП-уудын 200 км-ын радиус доторх ашигт малтмалын ордуудын нөөц баталгаагүй, бүрэн судлагдаагүй                                                                                                                                                | ✓ УТП-уудын үндсэн үйлдвэр байгуулахад нэгдлийн одоогийн тодорхойлсон шохойн нөөц 11 жилийн, жоншны нөөц 17 жилийн, Бор-Өндөрийн төмрийн нөөц 15 жилийн үйлдвэрлэлийн нөөцтэй байгаа нь төслийг 30-с доошгүй жил төлөвлөхөд хүндрэл учруулж байна.                          |



|         | МАКРО ОРЧИН БУЮУ ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛС                                                                                                                                                     | МИКРО БУЮУ ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС                                                                                                                                            |
|---------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| СУЛ ТАЛ | ✓ Ашигт малтмалын хайгуул хангалтгүй хийгдсэн                                                                                                                                           | ✓ Үндэсний геологийн албанаас хувийн хэвшлүүдийн ордуудын мэдээллийг судлахад нууцлалтай байдаг нь аж үйлдвэржилтийн төлөвлөгөөг нарийвчлан гаргахад саад учруулж байна. |
|         | ✓ БНХАУ-ын масс үйлдвэрлэлийн өртөг бага байгаа нь манай бүтээгдэхүүний өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна.                                                                         | ✓ Жоншны хүдрийг боловсруулалт хийхгүйгээр шууд экспортлох нь жилээс жилд нэмэгдэж байна.                                                                                |
|         | ✓ Хууль журмууд тодорхойгүй, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого сул                                                                                                             | ✓ УТП-уудын хөгжлийн төлөвлөлтөд тусгасан цахиур, хөнгөн цагаан зэрэг зарим ашигт малтмалын нөөц Нэгдлийн хэмжээнд байхгүй.                                              |
|         | ✓ Өндөр түвшний мэргэжилтэй хүний нөөцийн хомсдолтой                                                                                                                                    | ✓ Тавантолгой УТП, Бор-Өндөр УТП-уудад гадаргын усны нөөц байхгүй                                                                                                        |
|         | ✓ Улс төрийн богино хугацааны шийдвэр гаргалт, өөрчлөлтүүд ихтэй                                                                                                                        | ✓ Үйлдвэрлэл технологийн парк байгуулж байсан туршлагагүй                                                                                                                |
|         | ✓ Олон нийтийн паркийн талаарх ойлголт сул, итгэлгүй байдал                                                                                                                             | ✓ УТП-ийн төслүүдийн хүрээнд Нэгдлийн зарим ашигт малтмалын олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай.                                                                        |
|         | ✓ Томоохон төсөл хэрэгжих боломжтой нийт эдийн засгийн багтаамж бага.                                                                                                                   | ✓ УТП-д төлөвлөсөн зарим үйлдвэрүүд Монгол улсад баригдаж байгаагүй, ижил төстэй дотоодын сайн туршлага хомс                                                             |
|         | ✓ Техник, технологийн туршлага бага                                                                                                                                                     | ✓ БНХАУ-тай харьцуулахад эрчим хүчний үнэ өндөр                                                                                                                          |
|         | ✓ Төрийн байгууллагуудын хүнд суртал, нүсэр шат дамжлага                                                                                                                                | ✓ Үйлдвэрлэлийн хэмжээ багаас шалтгаалж, зарим бүтээгдэхүүний өртөг өндөр болох, боловсруулалтын түвшинг ахиулах боломж хязгаарлагдмал                                   |
|         | ✓ Ашигт малтмалуудыг шууд түүхийгээр нь их хэмжээгээр сорчлон экспортлох байдал                                                                                                         | ✓ 6 байршил дахь УТП-уудын тусгай зөвшөөрөл гараагүй, удирдлагын компанийн эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй.                                                               |
|         | ✓ Эрчим хүчний хомсдол, хүрэлцээгүй байдал                                                                                                                                              | ✓ Нэгдлийн харьяа компаниуд УТП-ийн хүрээнд харилцан түүхий эд, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин байхгүй                                        |
|         | ✓ Ордуудын сорчлон ашиглах нь цаашид үйлдвэрлэлд ашиглах дундаж түүхий эдийн агуулгыг бууруулж байна.                                                                                   | ✓ Төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль эрх зүйн орчинд нийтийн зориулалттай дэд бүтцийн төслүүдээс бусад төслийн харилцааг зохицуулаагүй                                 |
|         | ✓ Ашигт малтмалын ордуудын дагалдах эрдсийн судалгаа дутмаг                                                                                                                             | ✓ Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах журамгүй                                                                                                                        |
|         | ✓ Улсын хэмжээнд судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалт бага, энэ чиглэлийн байгууллага цөөн                                                                                           | ✓ 6 байршил дахь УТП-ийн газрыг улсын тусгай хэрэгцээнд аваагүй                                                                                                          |
|         | ✓ Улсын хэмжээнд нүүрс-хими, металлургийн хагас үйлдвэрлэлийн туршилт хийх техник бааз дутмаг                                                                                           | ✓ УТП-уудын нийт төслийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхой болоогүй                                                                                                       |
|         | ✓ Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулахад нэмэгдсэн өртгөөс АМНАТ тооцдог, боловсруулалтын түвшин ахиц, өндөр үнэ цэн бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусам өндөр татвар төлөх хуультай | ✓ УТП-уудын шаардлагатай хүний нөөц бүрдээгүй                                                                                                                            |

|         | МАКРО ОРЧИН БУЮУ ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛС                                                                                                                                                                                              | МИКРО БУЮУ ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС                                                                            |
|---------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|
| СУЛ ТАЛ | ✓ УТП-ийн зориулалттай газрыг удирдлагын компани эзэмших эрхгүй                                                                                                                                                                  | ✓ Туршилт судалгаа хийх өндөр түвшний лаборатори, материаллаг бааз дутмаг                                |
|         | ✓ Сэргээгдэх эрчим хүчний төсөл эхлүүлэх, тусгай зөвшөөрөл авах боломж хязгаарлагдсан                                                                                                                                            | ✓ УТП-уудын бүтээгдэхүүн бүрийн зах зээлийн нарийвчилсан судалгаа, өрсөлдөх чадварын судалгаа хангалтгүй |
|         | ✓ Вагон тээврийн хүрэлцээ, хүчин чадал хангалтгүй                                                                                                                                                                                | ✓ УТП-уудын байршил Засгийн газрын тогтоолоор албажаагүй                                                 |
|         | ✓ Төслийн олон төрөлт санхүүжилтийг хуулиар хориглосон                                                                                                                                                                           | ✓ Судалгаа хөгжүүлэлтийн чиглэлээр хангалттай төсөв зориулдаггүй                                         |
|         | ✓ Төрийн өмчийн ашигт малтмалыг дотоодын үйлдвэрүүд худалдан авах боломж хязгаарлагдсан                                                                                                                                          | ✓ Эрчим хүчний үнэ хөрш оронтой харьцуулахад харьцангуй өндөр                                            |
|         | ✓ Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, бичиг баримт, шат дамжлаг хэт нүсэр                                                                                                                                                | ✓ УТП-уудын ус, цахилгаан хангамжийн төслүүдийг шинээр барьж байгуулах шаардлагатай                      |
|         | ✓ Геополитикийн нөхцөл байдал хүндэрсэн, олон улсын зах зээлийн тодорхойгүй байдал                                                                                                                                               |                                                                                                          |
|         | ✓ БНХАУ-ын гангийн салбар уналтад орж, хэрэглээ огцом буурч байгаа. Үүнээс шалтгаалж коксжих нүүрсний үнэ буурч байна.                                                                                                           |                                                                                                          |
|         | ✓ УТП-ийн татварын болон татварын бус дэмжлэг хангалтгүй, хөрөнгө оруулагчдыг татах бодит хүчгүй                                                                                                                                 |                                                                                                          |
|         | ✓ Үйлдвэрлэлд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, химийн урвалж, түргэн элэгдэх материал, хөдөлмөр хамгааллын хэрэгслүүд гэх мэт дийлэнх бараа материал импортоор хангагддаг нь бүтээгдэхүүний өртгийг өсгөх гол хүчин зүйл болж байна |                                                                                                          |
|         | ✓ Эрдэмтэн судлаачдын инновац, судалгаа бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хөрөнгө оруулах, дэмжих бодлого сул                                                                                                                    |                                                                                                          |
|         | ✓ Их дээд сургуулиуд инженерийн тусгайлсан нарийн чиглэлийн хөтөлбөргүй                                                                                                                                                          |                                                                                                          |
|         | ✓ Төрийн байгууллагын бодлого, хөтөлбөрийн залгамжлах чанар сул                                                                                                                                                                  |                                                                                                          |
|         | ✓ Барилга бүтээн байгуулалтын улирал богинохон                                                                                                                                                                                   |                                                                                                          |
| БОЛОМЖ  | ✓ Гадаад оронд хөрөнгө оруулалтын орчны нэр хүнд муу                                                                                                                                                                             |                                                                                                          |
|         | ✓ Улсын хэмжээнд хүнд үйлдвэрлэл сул хөгжсөн нь салбарын харилцан хамтын нөөцийн дэмжлэг хангалтгүй нөхцөлийг үүсгэж байна                                                                                                       |                                                                                                          |
|         | ✓ УТП-уудын 200 км-ын радиус доторх нийт талбайд эзлэх хайгуулын талбай хэмжээ 3.2%, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эзлэх талбай 0.7%-д байгаа нь цаашид хайгуулын ажлыг эрчимжүүлснээр нөөцийг нэмэгдүүлэх потенциал өндөр       | ✓ Нэгдлийн зүгээс УТП-уудад шаардлагатай ашигт малтмалын хайгуулын ажлыг шинээр эхлүүлэх, эрчимжүүлэх    |